"Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын
3 дугаар хавсралт

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ 2025 он

| Д/д | Үйл ажиллагаа | № | Шалгуур үзүүлэлт | Зорилтот | Хүрсэн | Тайлбар | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх | | | | | | | |
| 1. | Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан (дотоод сургалт) | 1.1 | Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо: | 5-оос доошгүй удаа сургалт зохион байгуулах | 8 удаа зохион байгуулсан. | Яамны албан хаагчдыг чадавхижуулах 2025 оны сургалтын төлөвлөгөөний дагуу эхний хагас жилийн байдлаар Удирдлагын академийн багц сургалтад 6 албан хаагч, худалдан авах ажилллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтыг 2025 оны 1 дүгээр сарын 3-4-ний өдрүүдэд 25 албан хаагчийг хамруулан зохион байгуулсан.<br>-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын Хүний нөөцийн албан хаагчдад Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системийн шинэ модуль, дэд системүүдийг танилцуулах, түүнийг хэрэглээнд нэвтрүүлэх, систем хэрэглэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг Төрийн албаны зөвлөлтэй хамтран зохион байгуулж, Захиргааны нэгжийн дарга нар, Хүний нөөцийн албан хаагчид 78 ажилтан; цахимаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын орон нутаг дахь байгууллагуудын Газрын дарга, Захиргааны нэгжийн дарга, Хүний нөөцийн албан хаагчид 202, нийт 280 орчим албан хаагч оролцсон.<br>-Монгол бичгийн компютерийн сургалтыг 05 дугаар сарын 13-ны өдрөөс 4 долоо хоногийн | 100 |
| | | Үүнээс | Ажлын байран дахь сургалт | 1 | 1 | | |
| | | | Мэргэшүүлэх сургалт | 4 | 6 | | |
| | | | Туршлага солилцох арга хэмжээ | 1 | 1 | | |
| | | | Бусад | - | - | | |
| | | 1.2 | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо: | 80 | 315 /давхардсан тоогоор/ | | |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | 78 | 253 | | |
| | | | Эрэгтэй албан хаагч | 21 | 62 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Удирдах албан тушаалтан | 12 | 31 | хугацаанд Мягмар, Пүрэв гаригт нийт албан хаагчдад зохион байгуулсан.<br>-Албан хэрэг хөтлөлтийн сургалтыг ахмад ажилтан Б.Аюуш “Албан бичгийн боловсруулалт, анхаарах асуудлууд” сэдвээр албан хаагчдад зохион байгуулсан. | |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | 87 | 284 | | |
| | | 1.3 | Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал:<br>Нийт албан хаагчдад эзлэх хувь | 90-ээс дээш | 95 | Нийт сургалтад хамрагдах ёстой албан хаагчдын 95 хувь хамрагдсан. Албан томилолт болон ажлын заалшгүй шаардлагаар 5 хувь нь хамрагдаагүй. | |
| 2. | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан (гадаад сургалт) | 2.1 | Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо | 9 | 38 | Тайлант хугацаанд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 38 удаагийн Төрийн өндөр дээд хэмжээний айчлал, сургалт, арга хэмжээ, хурал, чуулганд нийт 41 /давхардсан тоогоор 62/ албан хаагчид албан томилолтоор ажилласан байна. Үүнд: Төрийн өндөр дээд хэмжээний айлчлалд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон 2 албан хаагч, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн аж байдлын комиссоос жил бүр зохион байгуулагддаг “Эмэгтэйчүүдийн аж байдлын чуулган /69 дүгээр/”-д Төрийн нарийн бичгийн дарга болон 2 албан хаагч /давхардсан/, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын ээлжит 113 дугаар Бага хуралд 3 албан хаагч /давхардсан/, 20 удаагийн сургалтад 31 албан хаагч /давхардсан/, 4 удаагийн арга хэмжээнд 7 албан хаагч /давхардсан/, 11 удаагийн хурал, зөвлөгөөнд 15 албан хаагч /давхардсан/-д тус тус оролцуулан ажилласан байна. | 100 |
| | | 2.2 | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо: | 56 | 61 | | |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | 23 | 45 | | |
| | | | Эрэгтэй албан хаагч | 5 | 16 | | |
| | | | Удирдах албан тушаалтан | 10 | 23 | | |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | 18 | 38 | | |
| | | 2.3 | Гадаад сургалтад хамруулсан байдал: | 10-аас дээш | 61 | | |

<table>
<tr><td>3.</td><td>Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал</td><td>3.1</td><td>Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)</td><td>25,5</td><td colspan="2">ТНБДаргын 2024.12.27-ны өдрийн А/199 тоот “Сургалтын зардал гаргах тухай” тушаалаар ГБХНХЯамны албан хаагчдын мэдлэг чадварыг сайжруулах, мэргэшүүлэх болон арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхолын зөрчлөөс сэргийлэх нь, Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг үр дүнтэй боловсруулах нь сэдэвт, 2025.03.26-ны өдрийн А/89 “Сургалтын зардал гаргах тухай” тоот тушаалаар Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр 2025.01.01-ний өдрөөс албан хэрэгээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулахаар заасантай холбогдуулан яамны албан хаагчдыг үндэсний бичгээр албан хэргээ хөтлөн явуулах чадварыг сайжруулж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор сургалтыг зохион байгуулсан. Мөн 2025.01.23-ны өдрийн А/11 тоот “Сургалтын зардал гаргах тухай” тушаалаар “Харилцааны ур чадвар” сэдэвт, 2025.02.17-ны өдрийн А/49 тоот “Сургалтын зохион байгуулах тухай” тушаалаар салбарын хүний нөөцийн албан хаагчдад Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим систем хэрэглэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт, 2025.04.07-ны өдрийн А/108 тоот тушаалаар “Байгууллагын сэтгэл засал” сэдэвт, 2025.04.21-ний өдрийн А/126 тоот тушаалаар “Сургалт, зөвлөгөөн зохион байгуулах тухай” тушаалаар “Хүний хөгжлийн цогц хөтөлбөр” сэдэвт, сургалтуудыг ГБХНХЯамны албан хаагчдын эрүүл мэнд, бие бялдарыг чийрэгжүүлэх, хамт олны нөхөрлөлийг бэхжүүлэх, салбарын хүний нөөцийг чадавхийг бэхжүүлэх зорилгоор сургалтыг зохион байгуулсан болно.</td><td>100</td></tr>
<tr><td>4</td><td rowspan="4">Албан хаагчдын шилжилт хөдөлгөөн</td><td>4.1</td><td>Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь (15%-аас доош байх)</td><td colspan="3">13/135*100=9.62%</td><td rowspan="4">100</td></tr>
<tr><td rowspan="3"></td><td>4.2</td><td>Шатлан дэвшүүлсэн албан хаагчийн тоо</td><td>-</td><td>20</td><td rowspan="3">Тайлант хугацаанд Эрхэлсэн түшмэлд 2, ахлах түшмэлд 3 нийт 5 албан хаагчийг тусгай шалгалтаар шатлан дэвшүүлсэн бол ангилал дотроо 3 байгууллага дотроос шатлан дэвшүүлсэн 6 өөр байгууллагаас шатлан дэвшүүлсэн 6 нийт 20 албан хаагчийг бүтцээр болон сул орон тоонд шатлан дэвшүүлсэн байна. Үүнээс эмэгтэй албан хаагч 15, эрэгтэй албан хаагч 5 байгаа бол Удирдах албан тушаалд 5, гүйцэтгэх албан</td></tr>
<tr><td rowspan="2">Үүнээс</td><td>Эмэгтэй албан хаагч</td><td>-</td><td>15</td></tr>
<tr><td>Эрэгтэй албан хаагч</td><td>-</td><td>5</td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Удирдах албан тушаалтан | - | 5 | тушаалд 15 албан хаагчийг шатлан дэвшүүлсэн байна. | |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | - | 15 | | |
| | | 4.3 | Шилжүүлсэн болон сэлгэн ажиллуулсан албан хаагчийн тоо | - | 34 | Тайлант онд салбар дотроо 6 бусад салбар луу 4 нийт 10 албан хаагч шилжин ажиллах хүсэлт гаргасны дагуу байгууллагын удирдлага хооронд тохиролцон шилжүүлэн ажиллуулсан. 1 албан хаагч сэлгэн ажилласан. Харин бүтцийн өөрчлөлтийн дагуу зарим газар хэлтсийн тоо буурсантай холбогдуулан 23 албан хаагчийг байгууллагын газар дотор шилжүүлэн ажиллуулсан. | |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | - | 25 | | |
| | | | Эрэгтэй албан хаагч | - | 9 | | |
| | | | Удирдах албан тушаалтан | - | 8 | | |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | - | 26 | | |
| Нийгмийн баталгааг хангах хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ | | | | | | | |
| 5. | Албан хаагчид олгосон цалин урамшуулал, нөхөх төлбөр, тусламж, дэмжлэг | | | - | 1,842,393,471 | . Тайлант оны гүйцэтгэлээр | |
| | **5.1.Улирлын урамшуулал олгосон байдал** | Нийт албан хаагчийн тоо | | 123 | 123 | 2025 онд холбогдох тушаалыг үндэслэн 123 албан хаагчдад нийт 1,842,393,471.87 төгрөгийн урамшуулал, хөнгөлөлт, тусламж, дэмжлэгийг олгосон байна | 100 |
| | | Урамшуулал олгосон албан хаагчийн тоо | | 114 | 114 | | |
| | | Үүнээс | удирдах | 17 | 17 | | |
| | | | гүйцэтгэх | 97 | 97 | | |
| | | Нийт олгосон урамшууллын хэмжээ | | 470,420,430 | 470,420,430 | 2025 оны холбогдох тушаалын дагуу нийт 114 албан хаагчдад 470,420,430 төгрөгийн урамшууллыг олгосон. | |
| | | | I улирал | - | - | - | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Үүнээс | II улирал | 285,284,343 төгрөг | | ГБХНХСайдын 2025.06.24-ний өдрийн Б/24 тоот, ТНБДаргын 2025.06.23-ны өдрийн А/207 тоот “Мөнгөн урамшуулал олгох тухай” тушаалаар 2025 оны хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшний үнэлгээгээр “Маш сайн”, “Хэвийн” ангилалд үнэлэгдсэн 103 төрийн жинхэнэ албан хаагчид, хөдөлмөрийн гэрээ, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлсэн 10 төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгосон.<br>ГБХНХСайдын 2025.05.26-ны өдрийн А/115 тоот, ТНБДаргын 2025.06.23-ны өдрийн А/206 тоот “Мөнгөн урамшуулал олгох тухай” тушаалаар Салбарын эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажилд идэвх санаачлагатай ажиллаж, онцгой хувь нэмэр оруулсан 18 албан хаагчдад мөнгөн урамшуулал олгосон. | |
| | | | III улирал | - | - | - | |
| | | | IV улирал | 185,136,086 төгрөг | | ГБХНХСайдын 2025.12.30-ны өдрийн Б/40 тоот, ТНБДаргын 2025.12.26-ны өдрийн А/322 тоот “Мөнгөн урамшуулал олгох тухай” тушаалаар 2025 оны хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшний үнэлгээгээр “Маш сайн”, “Хэвийн” ангилалд үнэлэгдсэн 98 төрийн жинхэнэ албан хаагчид, хөдөлмөрийн гэрээ, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлсэн 9 төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгосон. | |
| | | Цалингийн нийт санд эзлэх хувь | | 8 | 8 | | |
| | **5.2.Нөхөх төлбөрт олгосон зардал, нийт:** | албан хаагчийн тоо | | 33 | 187 | Холбогдох тушаалын дагуу нийт 187 албан хаагчдад 289,140,464 төгрөгийг олгосон. | 100 |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | | 24,622,494 төгрөг | 289,140,464 төгрөг | | |
| | 5.2.1.албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.2) | | | - | 135 | ТНБДаргын 2025.01.30-ны өдрийн А/17 тоот, 2025.07.22-ны өдрийн А/219 тоот тушаалаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, хууль тогтоомжийн талаар олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор | |
| | | | | - | 115,494,320 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нийт 9 хүн, ГБХНХСайдын 2025.01.31-ний өдрийн А/29 тоот тушаал, ТНБДаргын 2025.01.30-ны өдрийн А/18 тоот тушаалаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын орон нутгийн албан хаагчдын хойд бүсийн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулах зорилгоор 15 хүн, ТНБДаргын 2025.01.30-ны өдрийн А/20 тоот, 2025.07.07-ны өдрийн А/214 тоот, 2025.08.14-ний өдрийн А/225 тоот тушаалаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор мэдээ, сурвалжлага бэлтгэх, фото, видео архив бүрдүүлэх, харьяа байгууллагын үйл ажиллагаатай танилцах зорилгоор нийт 12 хүн, ТНБДаргын 2025.02.05-ны өдрийн А/25 тоот тушаалаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, хууль тогтоомжийн талаар олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор 12 хүн, ТНБДаргын 2025.02.05-ны өдрийн А/29 тоот тушаалаар Дорнод аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлөөс хэрэгжүүлж буй “Хүүхэд-Эрдэнэ” хүүхэд хамгааллын төслийн 2024 оны үйл ажиллагааг дүгнэх “Дорнод-Хүүхэд-Эрдэнэ” хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн зөвлөгөөнд оролцуулахаар 1 хүн, ТНБДаргын 2025.02.06-ны өдрийн А/30 тоот, 2025.05.19-ны өдрийн А/166 тоот, 2025.06.27-ны өдрийн А/211 тоот тушаалаар МУЗГ-ын 2022 оны 479-р тогтоолоор баталсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”-ыг үндэслэж, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтэд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийхээр нийт 14 хүн, ГБХНХСайдын 2025.02.06-ны өдрийн А/34 тоот тушаалаар МУЗГ-ын 2024 оны 237-р тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллахтай холбогдуулан, ТНБДаргын 2025.02.07-ны өдрийн А/32, А/33 тоот тушаалаар орон нутагт шинээр томилогдсон хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг чиглүүлэх, мэргэшүүлэх бүсчилсэн сургалтыг зохион байгуулахаар 6 хүн, ТНБДаргын 2025.02.18-ны өдрийн А/53 тоот тушаалаар Хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдэд нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг цаг алдалгүй | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үзүүлэх зорилготой хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан сум, хорооны нийгмийн ажилтан бэлтгэх бүсчилсэн сургалтын үйл ажиллагаанд оролцох зорилгоор 6 хүн, ТНБДаргын 2025.03.18-ны өдрийн А/78 тоот тушаалаар Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төрийн албаны шинэтгэл болон сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн сумдын төрийн албан хаагчдад сургалт, мэдээлэл өгөх, соён гэгээрүүлэх, хяналт шалгалт хийх, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах ажлаар Төрийн албаны зөвлөлийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан 2 хүн, ТНБДаргын 2025.03.20-ны өдрийн А/82 тоот, 2025.09.02-ны өдрийн А/244 тоот тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөмж, чиглэл өгөх, комиссын гишүүдийг чадавхжуулах ажлыг зохион байгуулахаар нийт 5 хүн, ТНБДаргын 2025 оны 04-05-р сарын А/105, А/121, А/125, А/134, А/138, А/153 тоот тушаалаар төрийн албаны шинэтгэл болон сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн албаны зөвлөлийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан нийт 8 хүн, ТНБДаргын 2025 оны 04-05-р сарын А/110 тоот, А/154 тоот, 2025.09.26-ны өдрийн А/260 тоот, А/266 тоот тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн хүрээнд орон нутагт зохион байгуулах цогц арга хэмжээг зохион байгуулахаар 25 хүн, 2025 оны 04-05-р сарын А/104, А/130, А/147 тоот тушаалаар МУ-ын Шадар сайдын 2025 оны “Бүсчилсэн хөгжил” хөдөлгөөн өрнүүлэх тухай удирдамж, Бүсчилсэн хөгжлийн үндэсний хорооны 2025 оны 01-р тогтоолоор баталсан “2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд 7 бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааны үеэр “Ажиллах хүч-Нийгмийн хамгаалал”-ын салбар хуралдааныг зохион байгуулах зорилгоор нийт 20 хүн тус тус дотоод албан томилолтын мөнгийг олгосон. | |
| | 5.2.2.албан ажлын хэрэгцээнд хувийн автомашин хэрэглэсний | албан хаагчийн тоо | - | - | Байхгүй | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 3.2) | нөхөх төлбөрийн хэмжээ | - | - | | |
| | 5.2.3.төрийн албан хаагчийн албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд учирсан хохирлыг нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 5.1, 5.2) | албан хаагчийн тоо | - | 32 | Ажилтнуудын ирүүлсэн хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг үндэслэн тэтгэмжийн тооцоог бодож харьяа нийгмийн даатгалын хэлтэсээр баталгаажуулан 32 ажилтанд тэтгэмжийг олгосон. | |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | - | 23,822,494 төгрөг | | |
| | 5.2.4.хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг, гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд эмчилгээний зардлыг нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 7.1) | албан хаагчийн тоо | - | 1 | ТНБДаргын 2025.10.09-ны өдрийн Б/280 тоот “Буцалтгүй тусламж олгох тухай” тушаалаар хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт олон жил ажилласан, төр нийгмийн зүтгэлтэн, байгууллагын ахмад настан Доржхандын Бямбаад элэгний хорт хавдраар өвдөж гадаад улсад эмчлүүлэх шаардлагын улмаас тусламж хүссэн тул эмчилгээний зардалд нь зориулж тусламж үзүүлсэн. | |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | - | 800,000 төгрөг | | |
| | 5.2.5.гадаад улс болон орон нутагт ажиллахаар томилогдсон төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 4.1) | албан хаагчийн тоо | - | 19 | ГБХНХСайдын 2025.02.04-ний өдрийн А/33 тоот тушаалаар БНСУлс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн бүтэц, орон тоо, захиргаа, хүний нөөцийн үйл ажиллагаатай танилцах, төвийн дүрэм, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг тогтоосон эрх зүйн актын хэрэгжилт, үр дүнд дүн шинжилгээ хийж ажиллуулах зорилгоор 1 хүн, ТНБДаргын 2025.02.14-ний өдрийн А/41 тоот тушаалаар Бүгд Найрамдах Узбекистан улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын Үндэсний баялгийн сангийн менежмент, орон сууцны санхүүжилтийн тогтолцоо, нийгмийн даатгалын шинэчлэлийн туршлага болон сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлсэн туршлагыг судлах зорилгоор 3 хүн, ТНБДаргын 2025.2.27-ны өдрийн А/66 тоот тушаалаар НҮБ-ын эдийн засаг, нийгмийн зөвлөлийн эмэгтэйчүүдийн аж байдлын 69-р чуулганд оролцохоор 1 хүн, ТНБДаргын 2025.03.06-ны өдрийн А/69 тоот тушаалаар Төрийн өндөр дээд хэмжээний айлчлалын бүрэлдэхүүнд багтсан тул 2 хүн, ТНБДаргын 2025.03.26-ны өдрийн А/88 тоот тушаалаар БНСУлс дахь Хөдөлмөр, нийгмийн | |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | - | 149,023,650 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамгааллын үйлчилгээний төвийн даргын ажлыг хүлээлцүүлэх, төвийн үйл ажиллагааны явц, хэрэгжилтэд дүгнэлт хийлгүүлэх зорилгоор 1 хүн, ТНБДаргын 2025.04.17-ны өдрийн А/123 тоот тушаалаар МУЗГ-ын Хэрэг эрхлэх газар, Бүгд Найрамдах Солонгос улсын хамтын ажиллагааны Койка байгууллагатай хамтран зохион байгуулж байгаа “Монгол Улсын төрийн албаны гүйцэтгэлийн тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд төрийн албан хаагчийг чадавхжуулах “Хүний нөөцийн менежмент” –ийн сургалтанд 1 хүн, ТНБДаргын 2025.04.28-ны өдрийн А/131 тоот тушаалаар Dell Technologies World Conference-д 1 хүн, ГБХНХСайдын 2025.05.20-ны өдрийн А/107 тоот тушаал, ТНБДаргын А/164 тоот тушаалаар Олон улсын гэр бүлийн чуулга уулзалтад 2 хүн, ТНБДаргын 2025.05.14-ний А/159 тоот тушаалаар Олон улсын хөдөлмөрийн бага хурлын ээлжит 113-р чуулганд 2 хүн, ГБХНХСайдын 2025.10.06-ны А/193 тоот тушаал, ТНБДаргын 2025.10.06-ны А/267 тоот тушаалаар Дэлхийн банк, Олон улсын валютын сангийн жилийн уулзалтад Монгол Улсын тэтгэврийн даатгалын тогтолцоог шинэчлэх техник туслалцааны төслийг ОУВС-ийн санхүүгийн дэмжлэгээр хэрэгжүүлэх асуудлыг хэлэлцүүлэхээр 2 хүн, ТНБДаргын 2025.10.24-ний А/278 тоот тушаалаар НҮБ-с зохион байгуулж байгаа Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний 4-р илтгэлийн хуралд оролцуулахаар 1 хүн, ГБХНХСайдын 2025.10.24-ний өдрийн А/292 тоот тушаал, ТНБДаргын 2025.10.24-ний А/281 тоот тушаалаар Нийгмийн хөгжлийн төлөөх Дэлхийн дээд хэмжээний 2-р уулзалтад 2 хүн оролцуулан тус тус гадаад томилолтын зардал олгосон болно. | |
| | 5.2.6.замын зардлыг нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 6.1) | албан хаагчийн тоо | - | - | Байхгүй | - |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | - | - | | |
| | **5.3.бусад нөхөх төлбөрт олгосон зардал, нийт:** | албан хаагчийн тоо | | 126 | Холбогдох тушаалын дагуу нийт 126 албан хаагчдад 736,211,008.35 төгрөгийг олгосон. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | | 736,211,008 төгрөг | | |
| | 5.3.1.төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардал болон ажилдаа ирэх, буцахад нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон нийтийн тээврийн унааны зардлын хэмжээ ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.2, 8.4) | албан хаагчийн тоо | | 123 | ТНБДаргын 2024.04.03-ны өдрийн А/74 тоот “Албан хаагчдад олгох хоол, унааны хөнгөлөлтийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тушаалын дагуу яамны албан хаагчдад олгох өдрийн хоолны зардлын хөнгөлөлтийг 25,000 төгрөг, ажилдаа ирэх, буцах унааны зардлын хөнгөлөлтийг 3,000 төгрөгөөр тооцож олгосон. | |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | | 716,792,008 төгрөг | | |
| | 5.3.2.ердийн галлагаатай сууцанд амьдардаг төрийн албан хаагчид өвлийн улирлын түлш худалдан авах зардлын зохих хэсгийг байгууллагаас нөхөн олгож болно. ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.3) | албан хаагчийн тоо | - | - | Байхгүй | |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | - | - | | |
| | 5.3.3.төрийн албанаас түр чөлөөлөгдсөн тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчид тухайн албан хаагчийн албан тушаалын 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.5) | албан хаагчийн тоо | - | 3 | ТНБДаргын 2025.04.30-ны өдрийн Б/91 тоот төрийн албанаас түр чөлөөлөх тухай тушаалаар ЭЗСТХОГ-ын шинжээч Б.Батмөнхийн гаргасан 6 сараас дээш хугацаагаар сургалтанд хамрагдах болсон тул төрийн албанаас түр чөлөөлүүлэх хүсэлтийг үндэслэн, ТНБДаргын 2025.08.01-ний өдрийн Б/136 тоот, ТНБДаргын 2025.09.22-ны өдрийн Б/253 тоот төрийн албанаас түр чөлөөлөх тушаалаар Засгийн газрын 2025 оны “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 7-р тогтоолоор тус яамны бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орж, орон тоо хасагдсан тул 2 ажилтныг төрийн албанаас тус тус түр чөлөөлсөн. | |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | - | 19,419,000 төгрөг | | |
| | 5.3.4.Төрийн албан хаагчийг эрхэлсэн ажил, эзэмшсэн мэргэжлийн дагуу 180 хүртэл | албан хаагчийн тоо | - | - | Байхгүй | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хоногийн хугацаагаар эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу төрийн хөрөнгө, бусад эх үүсвэрээр давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэхэд түүний эрхэлж байгаа албан тушаалын цалинг олгоно. ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.6) | нөхөх төлбөрийн хэмжээ | - | - | | |
| | **5.4.Төрийн албан хаагчид олгосон тусламж, нийт:** | албан хаагчийн тоо | - | 6 | Холбогдох тушаалын дагуу нийт 6 албан хаагчдад 328,161,068.33 төгрөгийг олгосон. | 100 |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | - | 328,161,068 төгрөг | | |
| | 5.4.1.өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн албан хаагчид олгосон нэг удаагийн буцалтгүй тусламж | албан хаагчийн тоо | | 5 | ТНБДаргын 2025.07.23-ны өдрийн Б/132, Б/133, 2025.08.29-ны өдрийн Б/151, 2025.09.25-ны өдрийн Б/273, 2025.11.26-ны өдрийн Б/306 тоот төрийн албанаас чөлөөлөх тухай тушаалаар тэтгэвэр тогтоолгох насанд хүрч, төрийн албанаас чөлөөлөгдөх тухай хүсэлтэд үндэслэн 5 ажилтныг төрийн албанаас чөлөөлөн, албан тушаалын үндсэн цалингийн 3 жилийн дунджаар тогтоосон дүнгээс төрийн албанд ажилласан нийт жилийн тоотой тэнцэх сарын тоогоор үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгосон. | |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | | 316,656,068 төгрөг | | |
| | 5.4.2.албан үүргээ гүйцэтгэх явцад амь нас хохирсон албан хаагчийн ар гэрт олгосон нэг удаагийн буцалтгүй тусламж | албан хаагчийн тоо | | 1 | ТНБДаргын 2025.07.23-ны өдрийн Б/131 тоот хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгох тухай тушаалаар нас барсан ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгож, гэр бүлээс нь ирсэн өргөдлийг үндэслэн 5 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний буцалтгүй тусламжийг олгосон. | |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | | 11,505,000 төгрөг | | |
| | | албан хаагчийн тоо | - | 10 | Холбогдох тушаалын дагуу нийт 10 албан хаагчдад 18,460,500 төгрөгийг олгосон. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **5.5.төрийн албан хаагчийн нийтлэг баталгаанд зарцуулсан зардал, нийт:** | нөхөх төлбөрийн хэмжээ | | 18,460,500 төгрөг | | 70 |
| | 5.5.1.ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй албан хаагчид 1.5 сарын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгосон | албан хаагчийн тоо | | 4 | ГБХНХСайдын 2025.08.25-ны өдрийн А/155 тоот, ТНБДаргын 2025.12.15-ны өдрийн Б/315 тоот тушаалаар ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй 4 ажилтанд 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгосон. | |
| | | нөхөх төлбөрийн хэмжээ | | 13,660,500 төгрөг | | |
| | 5.5.2.орон байраар хангагдахад төрөөс үзүүлсэн дэмжлэг | албан хаагчийн тоо | | 6 | ТНБДаргын 2025.01.02-ны өдрийн Б/02, ТНБДаргын 2025.01.23-ны өдрийн Б/14, 2025.02.20-ны өдрийн Б/41, 2025.03.28-ны өдрийн Б/67, 2025.04.21-ний өдрийн Б/80, 2025.06.13-ны өдрийн Б/113 тоот тушаалаар 6 ажилтанд шинэ байранд орсон тул хүсэлтэд үндэслэн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон. | |
| | | зарцуулсан хөрөнгийн хэмжээ | | 4,800,000 төгрөг | | |
| | 5.5.3.албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг сайжруулахад зарцуулсан зардал | зарцуулсан хөрөнгийн хэмжээ | - | - | Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. | |
| | 5.5.4.албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэг (жилд) 1-ээс дээш | албан хаагчийн тоо | - | 122 | Хөдөлмөрийн дотоод журмын 3.2.14-т Албан хаагчдыг жилд нэгээс доошгүй удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар тусгасны дагуу Хавдар судлалын үндэсний төвтэй 2024.12.18-ны өдрийн 01, 03/246 дугаар "Хамтран ажиллах гэрээ" байгуулан нийт 122 албан хаагчийг 2025 онд 3 багц 12 төрлийн шинжилгээнд хамруулсан. | |
| | | зарцуулсан хөрөнгийн хэмжээ | - | - | | |